



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/23

Пионер толгой

Хязгаарлалтын дэглэмийг  
цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн 17 дугаар зүйлийн 17.2.1, сумын Мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэмийн үед малын өвчлөл нэмэгдээгүй тул 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Тухайн мал сүрэгт шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажиллахыг “Хөгжил дэвшил нэгдэл” ХХК мал эмнэлгийн аж ахуй нэгжийн малын их эмч (Б.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Хүн амд зарлан мэдээлж заавар зөвлөгөө өгч ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Э.Хас-Очир), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642101135

Е/2022/Засаг дарга/Захирамж